



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 69

Баруун-Урт

“Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр”-ийг  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Эүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын “Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг жил бүрийн аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хандив тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

3. Харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Б.Эрдэнэтуяа/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн хороо, ИТХ-ын нарийн бичгийн дарга /А.Чулуунбат/ нарт даалгасугай.

ДАРГА  МӨНХБАТ

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСДЫН  
“НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэслэл:

Төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хөгжил чухал үүрэгтэй байдаг ба энэ нь тухайн байгууллагын ажиллах таатай орчин, нөхцөл, нийгмийн баталгааг бүрдүүлэх улмаар ажиллагсдын сэтгэл ханамжтай, тогтвор суурьшилтай ажиллах асуудалтай салшгүй хамааралтай юм.

2017 оны жилийн эцсийн байдлаар Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн салбарт 794 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байгаагаас 80.3 хувь нь эмэгтэй, 19,7 хувь нь эрэгтэйчүүд бөгөөд 64,5 хувь нь гэрлэсэн, 5,6% нь өрх толгойлсон, 5,2 хувь нь ганц бие байна.

Эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын 16.2 хувь нь амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, 94.5 хувь нь зээлтэй үүний 71.1 хувь нь цалингийн болон орон сууцны зээл, 15.4 хувь нь бизнесийн зээл, 5.4 хувь нь өргөн хэрэглээний зээл, 15 хувь нь сургалтын зээлтэй байна. Орон байрны хувьд 52.7 хувь нь орон сууцны төсөл хөтөлбөрийн хүрээнд, 2.5 хувь нь төр орон нутгийн өмчийн, 26.4 хувь нь амины, 4.5 хувь нь байгууллагаас олгосон хашаа байшин, 32 хувь нь гэр хороололд, 3.2 хувь нь түрээсийн байранд, 1.5 хувь нь хамаатан садныдаа амьдарч байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын өрхийн орлого нь тухайн өрхийн орон байр, сургалтын төлбөр, өдөр тутмын хэрэглээ зэрэг амьдралын баталгааг хангах эдийн засгийн хөшүүрэг болох ёстой боловч цалин хэлс нь нийгмийн баталгааг хангах санхүүгийн эх үүсвэр болж чадахгүй байгаа нь бүсийн хэмжээнд хийгдсэн нийгмийн баталгааг хангах суурь судалгаанаас харагдаж байгаа юм.

Тус судалгаанаас үзэхэд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй ажилчдын өрхийн орлого дунджаар 700,000 төгрөг, нэг гэр бүл дунджаар 4 ам бүлтэй байгаа ба өрхийн нэг иргэнд 175,000 төгрөг ноогдож байна. Энэ нь өрхийн амьжиргааны баталгаажих түвшинг бүсийн хувьд хангаж байгаа мэт боловч бусад бүстэй харьцуулахад хангалтгүй буюу анхаарах асуудал болоод байгаа юм. *Засгийн газрын 2017.02.15 хуралдаанаас гаргасан шийдвэрээр 2017 онд мөрдөх амьжиргааны доод түвшин баруун бүсэд 166,500, хангайн бүсэд 173,500, төвийн бүсэд 166,200, зүүн бүсэд 165,700, Улаанбаатар хотод 185,300 төгрөг.*

Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын ажиллах, амьдрах нөхцлийг жигд сайжруулж, нийгмийн асуудлыг үнэн зөв бодит судалгаанд үндэслэн нээлттэй ил тод шийдвэрлэх нь эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, идэвхи санаачилгатай ажиллуулах нөхцлийг бүрдүүлснээр иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирч, сэтгэл ханамж, дундаж наслалт нэмэгдэнэ.

1.2 Хамрах хүрээ:

Энэ хөтөлбөрт Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн салбарын нийт ажиллагсад хамрагдана.

## Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

### 2.1.Зорилго:

Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын ажиллах орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах замаар ажиллагсдын сэтгэл ханамжтай,тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

### 2.2 Зорилт:

2.2.1 Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох

2.2.2 Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын ажиллах нөхцөл, амьдрах орчин, баталгааг хангах үйл ажиллагааны чиглэл, сайжруулах арга замыг тодорхойлох

### Гурав. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт:

#### 3.1 Хугацаа: 2018-2021

#### 3.2 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.2.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө

3.2.2 Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хандив тусламж

3.2.3 Бусад эх үүсвэр, төсөл хөтөлбөр, сан

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

#### 4.1. Ажиллагсдыг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах

4.1.1 Орон нутагт шинээр төгсөж ирж байгаа эмч,эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс орон нутгийн удирдлага, ЭМБ-ын дэмжлэгээр орон нутгийн болон байгууллагын төсвөөр орон сууц, хашаа байшин, газар олгох зэргээр тусламж үзүүлэх

4.1.2 Эрүүл мэндийн салбарт олон жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа өрх толгойлсон, олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зэрэг ажиллагсдын судалгааг жил бүр гарган амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, гэр орон байр, хашаа байшингаар хангах дэмжлэг авах боломжийг эрэлхийлэх, шийдвэрлэх

#### 4.2. Ажиллах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр

4.2.1 Ажиллах орчин нөхцлийг стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

4.2.2 Ажиллагсдын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер,техник хэрэгсэлээр хангах асуудлыг ажилчдаас санал авсны үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх

4.2.3 Шинээр гэр бүл болох, хүүхэд төрүүлэх, шинэ байранд орох, төрийн одон медалиар шагнуулах зэрэгт байгууллагаас эд хөрөнгө болон мөнгөн тусламж үзүүлэхийг дотоод журмын заалтын дагуу шийдвэрлэнэ.

4.2.4 Ажиллах нөхцөл боломж хүнд нярай жирэмсэн эхийг 3 дагч шатлалд тээвэрлэх зардлыг орон нутгаас санхүүжүүлэх /бензин, онгоц гэх мэт/



4.2.5 Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, ажилтны өрхийн орлого буурч нэг гишүүнд ноогдох амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон ар гэрт нь гачигдал тохиолдсон үед байгууллагаас нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгоно

#### 4.3 Шагнал урамшуулал

4.3.1 Гамшгийн болон халдварт өвчний тархалт, осол гэмтлийн үед нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтанг алдаршуулан шагнах зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх

4.3.2 Шинээр аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргын нэрэмжит шагналыг бий болгож Эрхэлсэн ажлаараа бусдыг манлайлж ноцтой хүндрэлээс хүний амь насыг аварч гавъяа байгуулсан эмч, эмнэлгийн ажилчдыг жилд 1 удаа мөнгөн шагналаар шагнаж урамшуулах

#### 4.4. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

4.4.1 Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын эмчийг томилон ажиллуулж, жилд 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулна

4.4.2 Нийт ажиллагсдад эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх зорилгоор архи тамхи зэрэг эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэнд, зөв зохистой хооллолт, сэтгэл зүй, дасгал хөдөлгөөний сургалтанд хамруулж, витаминжуулах, аарц, чацаргана гэх мэт амин дэмтэй хүнсээр хангах ажлыг зохион байгуулна.

4.4.3 Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилчдын дунд урлаг, спортын үйл ажиллагааг зохион байгуулах, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах, урлаг спортын үйл ажиллагаанд байгууллагын зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хэвшүүлэх зэрэг арга хэмжээг тогтмолжуулах

4.4.4 Нийт ажиллагсад болон тэдний гэр бүлийнхнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан гэр бүл ажиллагсдын харилцааг сайжруулах үйл ажиллагааг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах

#### 4.5 Сургалт, хөгжлийн чиглэлээр

4.5.1 Салбарын хүний нөөцийн судалгаа, бодлого, төлөвлөлтөнд үндэслэн хүний нөөцийн хөгжлийн болон сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна

4.5.2 Ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургалтанд хамрагдахад нь дэмжлэг үзүүлнэ

4.5.3 Мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх хугацаанд тэднийг ажлаас нь түр чөлөөлөх, эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг олгох зэргээр дэмжлэг үзүүлнэ

4.5.4 Ажиллагсдыг улирал бүр ажлыг дүгнэн мөнгөн урамшуулал олгохоос гадна албан тушаал ахиулах, төрийн албан хаагчдыг зэрэг дэв нэмэх, төр засгийн шагналаар шагнах, гадаад дотоодын сургалтанд хамруулах, туршлага судлуулах зэрэг хууль тогтоомжинд нийцүүлэн урамшуулан дэмжинэ.

4.5.5 Шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийг төрийн сангийн болон байгууллагын, орон нутгийн зардлаар сургахад гэрээний үндсэн дээр ажлын байрыг хадгалах, цалингийн сандаа

багтаан цалинг бүтнээр болон зөрүүг олгох асуудлыг дотоод журам, засаг даргын мөрийн хөтөлбөр, сумдын Засаг дарга нартай байгуулах гурвалсан гэрээнд тусган хэрэгжүүлэх:

4.5.6 Орон нутагт ажиллаж байгаа нарийн мэргэжлийн эмч нарын чадавхийг сайжруулах зорилгоор гадаад болон дотоодын богино хугацааны сургалтанд багаар нь хамруулах зардлыг Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн жил бүрийн Аймаг, сумын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган орон нутгийн төсөвт тусгуулах:

4.5.7 Шинээр ажилд томилогдсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл, дотоод журам болон ёс зүйн дүрэм зэрэг шаардлагатай мэдээллээр хангах

4.5.8 Жил бүр үндсэн мэргэжил олгох сургалтанд 2-3 их эмчийг сургахад орон нутгийн дэмжлэг үзүүлэх

#### 4.6 Гэр бүлийг дэмжих чиглэлээр

4.6.1 Баяр ёслол, амралтын өдрүүдэд хамт олон гэр бүлээрээ тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

4.6.2 Ээлжийн амралтаараа эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлэхэд нь замын зардал болон бусад тусламж олгох нөхцөлийг судлан хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх

#### 4.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт

4.7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг Эрүүл мэндийн байгууллагуудаас Эрүүл мэндийн газарт хагас жил болон бүтэн жилээр тайлан хүргүүлнэ

4.7.2 Эрүүл мэндийн газраас Аймагийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлого, хөгжлийн хэлтэст хүргүүлэн тайлагнана.

4.7.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар ажилчид санал, хүсэлт, хөтөлбөрт тодотгол нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлж болно.



“НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа			Санхүүжилт	Шалгуур	Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан
		2019	2020	2021				
1	Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг АИХ-ын тэргүүлэгчдээр батлуулах					Төлөвлөгөө батлагдсан байна	ЭМГ	АИТХ
2	Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах	+	+	+		Нэгж бүр төлөвлөгөө боловсруулсан байна.	АНЭ, сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Сумын ЗДТГ
Ажиллагсдыг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах								
3	Харилцан хамтын ажиллагаатай банкуудын хамтын ажиллагааны гэрээнд тусгаж, Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг Ипотекийн зээлд хамруулах асуудлыг судлах	+	+	+		Жилд Ипотекийн зээлд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	АНЭ, сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Харилцагч банкууд
4	Эмнэлгийн ажилчдын орон сууц бариулах хөрөнгийн эх үүсвэр судлах	+				Эх үүсвэр олсон байх	ЭМГ	АИТХ АЗД
5	Боловсон хүчнээр хангах бодлогын хүрээнд орон нутагт ажиллах эмч мэргэжилтэнд сумын төр, захиргааны байгууллагаас орон сууцаар хангах, хашаа, газар олгох	+	+	+	АЗД-ын нөөц хөрөнгөөр Аймгийн төвд 5 шар барилгад  2 /ажилтан/ х 12.0сая төг х 3 /жил/ = 72.0сая төг  Сумдын ЗД-ын нөөц хөрөнгөөр Сумдын хувьд	Орон сууц, хашаа газар олгогдсон сумын эмчийн тоо	Сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Сумын ИТХ Сумын ЗД



					жилд 2 сум нэг нэг ажилтанд дэмжлэг үзүүлэх  2 /ажилтан/ x 25.0сая төг x 3 /жил/ = 150.0сая төг  Нийт 222.0 сая төгрөг			
6	Эрүүл мэндийн салбарт олон жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа өрх толгойлсон, олон хүүхэдтэй, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зэрэг ажиллагсдын судалгааг жил бүр гарган амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, орон байр, хашаа байшингаар хангах дэмжлэг авах боломжийг эрэлхийлэх, шийдвэрлэх	+	+		Сумдын ЗД-ын нөөц хөрөнгөөр  1/ажилтан/ x 25.0сая төг x 3 /жил/ = 75.0сая төг	Амьдрах орчин нөхцөл сайжирсан ажилчдын тоо	ЭМГ, АНЭ, өрх сумын ЭМТ	Аймгийн ЗД, Сумдын ЗД
Ажиллах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр								
7	Сум өрх, хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудын ҮЭ-ийн байгууллагад элсэх, санаачлагыг дэмжиж, ҮЭ-ийн байгууллагатай хамтын гэрээ байгуулах	+	+			ҮЭ-ийн байгууллагад элссэн эмнэлгийн байгууллагын тоо	ЭМГ, өрх сумын ЭМТ	ҮЭ-ийн холбоо
8	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл хооллолтыг дэмжсэн цайны газар ажиллуулах	+	+	+	АЗД, ЭМГ-ын хөрөнгөөр 23.8 сая төг	Цайны газартай болсон байна	АНЭ	АЗД, ЭМГ
9	Халдварт, сүрьеэ, мэс засал, төрөх, яаралтай тусламжийн тасгийг халуун усаар хангах	+			Улсын төсвийн хөрөнгөөр 200.0 сая төгрөг	Халуун устай болсон байна.	АНЭ	Аймгийн ЗД, ЭМГ
10	Алжаал тайлах өрөөг тохижуулах, байгууллагын гадна ногоон байгууламжийг	+	+	+	ЭМС-ын байгууллагын болон, хандив	Алжаал тайлах өрөөтэй болсон байгууллагын тоо,	Сум дундын эмнэлэг,	Ойжуулалт ОНӨҮГ



	нэмэгдүүлэх,				тусламжийн хөрөнгөөр 14,9 сая төгрөг	Ногоон байгууламжтай болсон байна. Тарьсан модны тоо	сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	
11	Илүү цагийн хөлсийг жигд, хүртээмжтэй олгох, журмаар зохицуулах	+	+	+		Илүү цагийн хөлс олгогдсон ажилчдын тоо	Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМЯ, ЭМД, ЭМГ, ҮЭ байгууллага
12	Эмч эмнэлгийн мэргэжилтэн нэг бүрийг хариуцлагын даатгалд заавал хамруулах	+	+	+		Хариуцлагын даатгалд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМЯ, ЭМГ
13	Шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгсэлийн судалгааг авч, төсөвт суулгах талаар оруулах	+	+	+	ЭМС-ын байгууллагын болон, хандив тусламжын хөрөнгөөр 27,3 сая төгрөг	Компьютер, техник хэрэгслэлээр хангагдсан ажилчдын тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМЯ, ЭМГ
14	Түлээ нүүрс олгох асуудлыг оруулах	+	+	+	Тухайн байгууллагын хөрөнгөөр 5,4 сая төгрөг			
15	Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, ажилтны өрхийн орлого буурч нэг гишүүнд ноогдох амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон ар	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 5,4 сая төгрөг	Буцалтгүй тусламжинд хамрагдсан хүний тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ,	Аймгийн ЗД, Сумдын ЗД, ҮЭ холбоо



	гэрт нь гачигдал тохиолдсон үед байгууллагаас нэг удаагийн буцалтгүй тусламж, цалинтай чөлөө олгож сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх						хувийн хэвшлийн ЭМБ-ууд	
Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр								
16	Байгууллага бүр ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмчийг томилох, жилд 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэн ажиллах	+	+	+		Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан, эмчлүүлсэн эмч ажилчдын тоо	Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМГ, АНЭ
17	Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах багийг томилох. картжуулах	+	+	+		Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч ажилчдын тоо	Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМГ
18	Гурав дахь шатлалын нарийн мэргэжлийн эмч нарыг үзлэгийг 2 жилд 1 удаа орон нутагт зохион байгуулах	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 2.4 сая төгрөг	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч ажилчдын тоо	Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМГ, 3-р шатлалын эмнэлэг
19	3.1.4.Эмч эмнэлгийн ажиллагсдын эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлэх	+	+	+	АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 0,5 сая төгрөг	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага жилд 2-3 байгууллага зэргээ ахиулсан байх	АНЭ, сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АНЭ, өрх сумын ЭМТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
20	Эмнэлгийн ажилтнуудын ар	+	+	+		Урьдчилан	ЭМГ,	ЭМГ, АНЭ

	гэрийг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг байгууллага дээрээ зохион байгуулах					сэргийлэх үзлэгт хамрагдсан гэр бүлийн гишүүдийн тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	
21	Эрүүл мэндийн салбарын ажилчдын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа хийж, зан үйлийг өөрчлөх арга хэмжээг зохион байгуулах	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 5.0 сая	Судалгаатай болсон байна. Эрсдэлт зан үйлээ өөрчилсөн эмч ажилчдын тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АШУУИС, ЭМГ
22	Нийт ажиллагсдад эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх зорилгоор архи тамхи зэрэг эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэнд, зөв зохистой хооллолт, сэтгэл зүй, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцлийг бүрдүүлж, сургалтанд хамруулах	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 1.0 сая төгрөг	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АШУУИС, ЭМГ
23	Зан үйл өөрчлөх стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд сургах сургалтыг зохион байгуулах	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 1.0 сая төгрөг	Сургалтанд 18 байгууллагын НЭМ-ийн ажилчид хамрагдсан байна.	ЭМГ	АШУУИС-НЭМС
24	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд урлагийн наадмыг зохион байгуулах	+		+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 5,0 сая төгрөг	Эрүүл мэндийн салбарын бүх байгууллага оролцож, зохион байгуулагдсан байна.	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЗДТГ, ҮЭ, СЗДТГ, ЭМГ
25	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд спортын наадмыг		+		ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн	Эрүүл мэндийн салбарын бүх	АНЭ, Сум дундын	ЗДТГ, ҮЭ, Сумдын ЗДТГ,



	зохион байгуулах				хөрөнгөөр 5,0 сая төгрөг	байгууллага оролцож, зохион байгуулагдсан байна.	эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМГ
26	Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцлийг бүрдүүлж, тогтмол хичээллэж, бие бялдарын сорилын түвшинг ахиулах	+	+	+	ЭМГ, АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн хөрөнгөөр 9,7 сая төгрөг	Тогтмол дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг ажилчдын тоо, сорилын түвшин ахисан хүмүүсийн тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМГ
27	Рашаан сувиллын байгууллагуудад эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулах, зохион байгуулах	+	+	+	АЗД, СЗД-ын нөөц хөрөнгөөр 15.0 сая төгрөг	Рашаан сувиллын байгууллагуудад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	
28	Баяр ёслол, амралтын өдрүүдэд хамт олон гэр бүлээрээ тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	+	+	+		Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан арга хэмжээний тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Бусад төрийн болон ТББ
Сургалт хөгжлийн чиглэлээр								
29	Шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийг төрийн сангийн болон байгууллагын, орон нутгийн зардлаар сургахад гэрээний үндсэн дээр ажлын байрыг хадгалах, цалингийн сандаа багтаан цалинг бүтнээр болон зөрүүг олгох асуудлыг	+	+	+		Дотоод журам, гурвалсан тусгагдсан ЭМБ-ийн тоо,	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн	АЗД, Сумдын ЗД, ЭМГ

	дотоод журам, засаг даргын мөрийн хөтөлбөр, сумдын Засаг дарга нартай байгуулах гурвалсан гэрээнд тусган хэрэгжүүлэх.						ЭМБ-ууд	
30	Орон нутгийн зардлаар нарийн мэргэжлийн эмч нарыг жил тутамд 1-6 сарын сургалтанд 3 дахь шатлалын эмнэлгүүдэд хамруулах /сургалтын төлбөр/	+	+	+	Жилд 4 эмч, сувилагч бэлтгэх. 40 сая төгрөг	Жилд 4 эмч, сувилагч хамруулсан байна	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ
31	Үндсэн мэргэжил олгох сургалтанд эмч нарыг сургахад орон нутгийн дэмжлэг үзүүлэх	+	+	+	СЗД болон тухайн байгууллагын хөрөнгөөр 2 /эмч/ х 300242 төг /1 эмчийн цалингийн зөрүү/ х 3 жил = 1.801.452төг	Жилд 2-3 эмчийг хамруулсан байна	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АЗД, Сумдын ЗД, ЭМГ
32	Нарийн мэргэжлийн эмч нарын багийг /их эмч, сувилагч/ 3 дахь шатлалын эмнэлгүүдэд сургах	+	+	+	АЗД, СЗД-ын нөөц хөрөнгөөр 6 /хүн/ х 350.000 төг /1 эмчийн зардал/ х 3 жил = 6.300.000төг	Жилд 1 баг сургагдсан байна	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ
33	Нарийн мэргэжлийн эмч нарын дунд ажил мэргэжлийн уралдаан зарлаж тэргүүлсэн эмч нарыг гадаад аялалд явуулж урамшуулах	+	+	+	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө 3 хүн х 2,0 сая төг /Тайланд явах зардал/ =6.0 сая төгрөг	Урамшуулалд хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн тоо	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн	АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ

							ЭМБ-ууд	
34	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гадаадад сургалтанд хамруулах, туршлага судлах танилцах, аялалд явуулах	+	+	+	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Солонгост 2 хүн х 14 хоног х 0,5 сая төг /нэг хоногийн зардал/ =14,7 сая төгрөг  БНХАУ-д 6 хүн х 7 хоног х 0,1 сая төг /нэг хоногийн зардал/ =4,8 сая төгрөг Нийт=19,5 сая төгрөг	Гадаадад туршлага судалсан эмч мэргэжилтнүүдийн тоо	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ
35	Жилд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг орон нутгийн зардлаар гадаад сургалтанд хамруулах талаар судлах холбоо тогтоох, суралцуулах / Аймаг, сумын Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган орон нутгийн төсөвт тусгуулах/	+	+	+	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 19,6 сая төгрөг	Гадаадад урт богино хугацааны сургалтанд хамрагдсан эмч нарын тоо	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ
36	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор багш урьж ажиллуулах, /багшийн зардал, байрыг даах г.м/	+	+	+	Тухайн байгууллагын төсвөөр 3.0 сая төгрөг	Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн тоо	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, сум ерхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ
37	Эмч, эмнэлгийн ажилтнуудыг судалгаа шинжилгээний ажил хийх, үйл ажиллагаатай холбоотой төсөл хөтөлбөр	+	+	+	Тухайн шатны Засаг даргын хөрөнгөөр 3.0 сая төгрөг	Судалгаа шинжилгээний ажил хийсэн эмч мэргэжилтнүүдийн	ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг,	АЗДТГ, Сумдын ЗДТГ ЭМГ

	хэрэгжүүлэх зэрэгт санхүүгийн дэмжлэгийг жил бүр үзүүлэх					тоо	сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	
38	Зэргийн шалгалт, Эрдмийн зэрэг цол хамгаалах зэрэгт дэмжлэг үзүүлэх	+	+	+		Дэмжлэг үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилчдын тоо	АНЭ, Сум дундын эмнэлэг, сум өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Тухайн байгууллага
Шагнал урамшуулал								
39	"Алтан гартай - эмч", "Хүнлэг Эчэрэнгүй - сувлагч", "Санагчлагч эмнэлгийн ажилтан" зэрэг эмч, ажиглагсдыг идэвхижүүлсэн болзолт уралдаануудыг зохион байгуулах	+				АИХ-ын нэрэмжит шагнал шинээр бий болгох 3 хүн x 1,0 сая төгрөг x 3 жил = 9,0 сая төгрөг	Уралдааны дүн, үр дүн	АНЭ Сум өрхийн ЭМТ Хувийн хэвшил
40	Гамшгийн болон халдварт өвчний тархалт, осол гэмтлийн үед нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтанг алдаршуулан шагнах зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх	+				Тухайн шатны ЗД-ын нөөц хөрөнгөөр 4 хүн x 1,0 сая төгрөг x 3 жил = 12,0 сая төгрөг	Шагнал авсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо санхүүжилт	ЭМГ АЗДТГ, Сумдын ЗДТГ
41	Шинээр аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргын нэрэмжит шагналыг бий болгож Эрхэлсэн ажлаараа бусдыг манлайлж ноцтой хүндрэлээс хүний амь насыг аварч гавьяа байгуулсан эмч эмнэлгийн ажилчдын багийг жилд 1 удаа мөнгөн шагналаар шагнаж урамшуулах	+	+	+		Орон нутгийн төсвөөс 6 хүн x 1,0 сая төгрөг x 3 жил = 18,0 сая төгрөг	Шагнал авсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо санхүүжилт	ЭМГ АЗДТГ, Сумдын ЗДТГ